

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/222/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
2024 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Baasansurens@audit.gov.mn">Baasansurens@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-17
4. Аудитын тайлан	17-21
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.АЛТАНТУЯА ТАНАА

2024.02.23 № СА-2024/222-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газар нь тайлант оны батлагдсан төсвийг нийт 134,984.5 мянган төгрөг / Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 5,241.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 36.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 139.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 15.5 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 0.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 79.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 87.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 129,382.2 мянган төгрөг/-өөр хэмнэж, жилийн эцэст татан төвлөрүүлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Б/35 дугаар захирамжаар тус газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг анх томилсон бол тайлант онд Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт орсноор БШУС-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Б/99 дүгээр тушаалаар Ч.Алтантуяаг газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр дахин томилсон байна.

Ингэснээр тус газрын үйл ажиллагааг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж удирдан, чиглүүлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус газар нь тайлант оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд 9 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 94.1 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,490,379.00</b>	<b>16,724,249.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,050,000.00</b>	<b>4,500,000.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,050,000.00	4,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,440,379.00</b>	<b>12,224,249.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>10,440,379.00</b>	<b>12,224,249.00</b>
35410	Бичиг хэргийн материал	-	251,870.00
35420	Аж ахуйн материал	9,456,379.00	11,447,379.00
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	525,000.00
35450	Барилгын засварын материал	484,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>172,155,558.06</b>	<b>94,651,979.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>172,155,558.06</b>	<b>94,651,979.75</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>172,155,558.06</b>	<b>94,651,979.75</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,577,204.29)	(18,557,455.35)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	250,722,796.25	257,280,084.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,760,923.12)	(179,616,525.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,406,220.49	26,485,009.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,276,406.27)	(25,414,133.76)
39217	Ном	820,000.00	875,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>183,645,937.06</b>	<b>111,376,228.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,050,000.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,050,000.00</b>	<b>-</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,050,000.00</b>	<b>-</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,050,000.00</b>	<b>-</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,050,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>182,595,937.06</b>	<b>111,376,228.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>182,595,937.06</b>	<b>111,376,228.75</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	211,787,128.44	211,787,128.44
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	211,787,128.44	211,787,128.44
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(29,191,191.38)</b>	<b>(100,410,899.69)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	41,156,540.36	(29,191,191.38)
51220	Тайлант үеийн үр дүн	(70,347,731.74)	(71,219,708.31)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>183,645,937.06</b>	<b>111,376,228.75</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,501,635,610.40</b>	<b>5,195,594,172.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>214,192,966.40</b>	<b>306,997,730.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>214,192,966.40</b>	<b>306,997,730.26</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,195,706.47	1,489,121.84

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	204,997,259.93	305,508,608.42
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,287,442,644.00</b>	<b>4,888,596,442.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,144,796,600.00</b>	<b>4,773,748,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,144,796,600.00	4,773,748,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>142,646,044.00</b>	<b>114,848,342.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,321,275.00	3,975,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,324,769.00	110,444,942.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	428,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,571,983,342.14</b>	<b>5,258,364,593.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,571,983,342.14</b>	<b>5,258,364,593.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>842,827,819.24</b>	<b>1,075,520,218.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>314,196,108.57</b>	<b>463,109,113.53</b>
210101	Үндсэн цалин	205,047,922.99	282,035,866.89
210102	Нэмэгдэл	56,494,865.45	105,741,649.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,807,800.00	38,001,361.64
210104	Урамшуулал	20,845,520.13	37,330,235.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,475,154.65</b>	<b>57,194,579.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,183,128.24	39,625,878.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,183,448.25	4,673,585.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,529,298.82	3,712,468.12
210204	Ажилгүйдлийн даатгал	598,116.31	834,786.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,981,163.03	8,347,861.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,817,994.51</b>	<b>32,170,607.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,072,810.51	3,508,443.28
210302	Түлш, халаалт	27,859,574.00	27,862,574.00
210303	Цэвэр, бохир ус	885,610.00	799,590.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>230,633,418.93</b>	<b>313,902,967.37</b>
210401	Бичиг хэрэг	2,798,800.00	2,004,080.00
210402	Тээвэр, шатахуун	11,478,569.00	3,843,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	908,090.00	427,039.95
210404	Ном, хэвлэл	24,000.00	91,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	217,200.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,611,050.00	1,881,400.00
210408	Бараа материал акталсны зардал	2,665,450.00	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	208,930,259.93	305,436,047.42
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,159,800.00</b>	<b>1,754,400.00</b>

210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	-
210604	Урсгал засвар	4,659,800.00	1,754,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,232,150.00</b>	<b>76,999,622.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,232,150.00	76,999,622.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,819,674.37</b>	<b>3,489,010.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,476,929.37	3,197,640.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,120.00	117,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	53,700.00	55,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>157,493,518.21</b>	<b>126,899,919.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,666,200.00	706,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,424,250.00	37,350,606.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,403,068.21	88,843,312.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,729,155,522.90</b>	<b>4,182,844,374.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,705,335,772.00</b>	<b>4,046,442,823.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,049,669,750.00	2,240,243,239.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,593,841,022.00	1,804,338,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,825,000.00	1,861,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,819,750.90</b>	<b>136,401,551.35</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,817,359.20	134,984,457.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,391.70	1,417,094.05
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(70,347,731.74)</b>	<b>(62,770,420.81)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>8,449,287.50</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	8,449,287.50
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(70,347,731.74)</b>	<b>(71,219,708.31)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,287,442,644.00</b>	<b>4,889,646,442.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,287,442,644.00</b>	<b>4,889,646,442.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,144,796,600.00</b>	<b>4,773,748,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,144,796,600.00	4,773,748,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>142,646,044.00</b>	<b>115,898,342.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,321,275.00	3,975,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,324,769.00	110,444,942.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,478,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,277,836,654.00</b>	<b>4,871,346,542.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,277,836,654.00</b>	<b>4,871,346,542.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>547,631,131.10</b>	<b>683,897,167.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>314,246,108.57</b>	<b>462,985,305.27</b>
210101	Үндсэн цалин	207,685,265.53	281,912,058.63
210102	Нэмэгдэл	55,304,274.07	105,741,649.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,804,700.00	38,001,361.64
210104	Урамшуулал	20,451,868.97	37,330,235.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,475,154.65</b>	<b>57,318,387.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,183,128.24	39,749,686.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,183,448.25	4,673,585.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,529,298.82	3,712,468.12
210204	Ажилгүйдлийн даатгал	598,116.31	834,786.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,981,163.03	8,347,861.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,817,994.51</b>	<b>32,170,607.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,072,810.51	3,508,443.28
210302	Түлш, халаалт	27,859,574.00	27,862,574.00
210303	Цэвэр, бохир ус	885,610.00	799,590.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,431,699.00</b>	<b>8,865,789.95</b>
210401	Бичиг хэрэг	6,731,800.00	2,255,950.00
210402	Тээвэр, шатахуун	11,978,569.00	3,868,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	908,090.00	427,039.95
210404	Ном, хэвлэл	24,000.00	91,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	217,200.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,572,040.00	2,003,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,567,900.00</b>	<b>3,011,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,424,100.00	1,741,000.00
210604	Урсгал засвар	5,143,800.00	1,270,400.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>17,232,150.00</b>	<b>76,999,622.00</b>
210702	Дотоод албан томиллолт	17,232,150.00	76,999,622.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,819,674.37</b>	<b>3,589,010.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,476,929.37	3,297,640.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,120.00	117,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	53,700.00	55,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>67,040,450.00</b>	<b>38,957,045.45</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,666,200.00	706,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,374,250.00	38,251,045.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,730,205,522.90</b>	<b>4,187,449,374.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,705,335,772.00</b>	<b>4,046,547,823.00</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,049,669,750.00	2,240,243,239.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,593,841,022.00	1,804,338,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,825,000.00	1,966,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,869,750.90</b>	<b>140,901,551.35</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,817,359.20	134,984,457.30
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,052,391.70	5,917,094.05
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>9,605,990.00</b>	<b>18,299,900.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>9,605,990.00</b>	<b>18,299,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,605,990.00</b>	<b>18,299,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,605,990.00</b>	<b>18,299,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,605,990.00	18,299,900.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(9,605,990.00)</b>	<b>(18,299,900.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	41,156,540.36	252,943,668.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	-	41,156,540.36	252,943,668.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(70,347,731.74)	(70,347,731.74)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	(29,191,191.38)	182,595,937.06
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	(29,191,191.38)	182,595,937.06
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	-	(29,191,191.38)	182,595,937.06
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-

16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(71,219,708.31)	(71,219,708.31)
<b>20</b>	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>211,787,128.44</b>	<b>-</b>	<b>(100,410,899.69)</b>	<b>111,376,228.75</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,773,748,100.00</b>	<b>4,638,763,642.70</b>	<b>134,984,457.30</b>	<b>97.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,773,748,100.00</b>	<b>4,638,763,642.70</b>	<b>134,984,457.30</b>	<b>97.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>599,463,100.00</b>	<b>593,860,819.70</b>	<b>5,602,280.30</b>	<b>99.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>468,227,100.00</b>	<b>462,985,305.27</b>	<b>5,241,794.73</b>	<b>98.9</b>
210101	Үндсэн цалин	242,365,700.00	281,912,058.63	(39,546,358.63)	116.3
210102	Нэмэгдэл	144,168,600.00	105,741,649.42	38,426,950.58	73.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,944,000.00	38,001,361.64	(6,057,361.64)	119.0
210104	Урамшуулал	49,748,800.00	37,330,235.58	12,418,564.42	75.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,355,000.00</b>	<b>57,318,387.70</b>	<b>36,612.30</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,576,900.00	39,749,686.61	(1,172,786.61)	103.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,694,500.00	4,673,585.16	20,914.84	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,755,600.00	3,712,468.12	43,131.88	98.9
210204	Ажилгүйдлийн даатгал	938,900.00	834,786.10	104,113.90	88.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,389,100.00	8,347,861.71	1,041,238.29	88.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,310,000.00</b>	<b>32,170,607.28</b>	<b>139,392.72</b>	<b>99.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,387,700.00	3,508,443.28	(120,743.28)	103.6
210302	Түлш, халаалт	25,162,900.00	27,862,574.00	(2,699,674.00)	110.7
210303	Цэвэр, бохир ус	3,759,400.00	799,590.00	2,959,810.00	21.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,946,900.00</b>	<b>7,945,589.95</b>	<b>1,310.05</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	2,325,700.00	1,749,750.00	575,950.00	75.2
210402	Тээвэр, шатахуун	3,399,000.00	3,399,000.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	106,900.00	427,039.95	(320,139.95)	399.5
210404	Ном, хэвлэл	93,000.00	146,400.00	(53,400.00)	157.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,300.00	220,000.00	460,300.00	32.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,342,000.00	2,003,400.00	(661,400.00)	149.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,271,800.00</b>	<b>21,256,300.00</b>	<b>15,500.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	20,000,000.00	19,985,900.00	14,100.00	99.9
210604	Урсгал засвар	1,271,800.00	1,270,400.00	1,400.00	99.9

2107	Томилолт, зочны зардал	2,132,100.00	2,131,410.00	690.00	100.0
210702	Дотоод албан томилолт	2,132,100.00	2,131,410.00	690.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,885,400.00	1,805,810.00	79,590.00	95.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,591,100.00	1,514,440.00	76,660.00	95.2
210803	Даатгалын үйлчилгээ	119,800.00	119,250.00	550.00	99.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,200.00	117,120.00	1,080.00	99.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	56,300.00	55,000.00	1,300.00	97.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,334,800.00	8,247,409.50	87,390.50	99.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	789,100.00	706,000.00	83,100.00	89.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,545,700.00	7,541,409.50	4,290.50	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,174,285,000.00	4,044,902,823.00	129,382,177.00	96.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,343,770,900.00	2,240,243,239.00	103,527,661.00	95.6
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,830,192,600.00	1,804,338,084.00	25,854,516.00	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	321,500.00		100.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,773,748,100.00	4,638,763,642.70	134,984,457.30	97.2
31	Улсын төсвөөс санхүүжих	4,773,748,100.00	4,638,763,642.70	134,984,457.30	97.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,773,748,100.00	4,638,763,642.70	134,984,457.30	97.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	31	22	9	71.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	21	9	70.0
620001	Удирдах ажилтан	1		1	
620002	Гүйцэтгэх ажилтан	21	13	8	61.9
620003	Үйлчлэх ажилтан	8	7	1	87.5
620004	Гэрээт ажилтан		1	-1	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	115,898,342.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,898,342.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,336,247.95
2104	Хангамж, бараа материалын зардал	975,200.00
210401	Бичиг хэрэг	506,200.00
210402	Тээвэр, шатахуун	469,000.00
2107	Томилолт, зочны зардал	74,868,212.00
210702	Дотоод албан томилолт	74,868,212.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,783,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,783,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,709,635.95</b>
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	30,709,635.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,562,094.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,645,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,645,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,917,094.05</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,917,094.05
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>115,898,342.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>115,898,342.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>115,898,342.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,975,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,444,942.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,478,400.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар /цаашид аймгийн БШУГ гэх/ нь "Иргэн бүрийг бие даан суралцах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, технологийг хүртээмжтэй, чанартай олгоно." гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах, өөрчлөх, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох.
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх.
- Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох эрх зүйн баримт бичигт заасны дагуу эрх бүхий байгууллагад гаргаж өгөх.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
- Харьяаны ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загвар батлах.
- Шинжлэх ухаан, технологи, инновацын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар *Дотоод аудитын хэлтэстэй* -аас хяналт шалгалт хийснээс гадна сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн БШУГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн БШУГ -ын мөрдөж байгаа “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн БШУГ -ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,269.7 мянган төгрөгөөр буюу 39.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Авлага	1,050.0	4,500.0	3,450.0
Бараа материал	10,440.4	12,224.3	1,783.9
Үндсэн хөрөнгө	172,155.5	94,651.9	(77,503.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>183,645.9</b>	<b>111,376.2</b>	<b>(72,269.7)</b>
Өр төлбөр	1,050.0	-	(1,050.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	183,645.9	111,376.2	(72,269.7)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>183,645.9</b>	<b>111,376.2</b>	<b>(72,269.7)</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 3,450.0 өссөн нь өмнөх оны эцэст татан төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагаас 1,050.0 мянган төгрөгийн барагдуулж, БЕГ-ын даргын 2023 оны А/407 дугаар тушаалын дагуу зохион байгуулагдах олимпиадын санхүүжилт 4,500.0 мянган төгрөгийг оны эцэст төвлөрүүлж, авлагаар бүртгэсэнээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 94,651.9 мянган төгрөг болж 77,503.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 18,299.9 мянган төгрөг /18,244.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 55.0 мянган төгрөгийн ном/-ийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан, 2,353.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан зэргээр нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тогтоолын дагуу нийт 13,961.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг, мөн өдрийн 124 дүгээр тогтоолоор 36,221.0 мянган төгрөгийн Киа карнавал суудлын автомашиныг тус тус акталж, 88,843.3 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Аймгийн БШУГ нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 776,166.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 84,482.8 мянган төгрөг,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 10,560.3 мянган төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,053.5 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 11,516.9 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 1,020.0 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 27,448.2 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 4,579.9 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 11,142.2 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 36,019.2 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 4,988.5 мянган төгрөг зэрэг нийт 206,811.5 мянган төгрөгөөр бууруулж, 569,355.3 мянган төгрөгөөр баталсан бол боловсролын салбарын ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 4,283,692.4 мянган төгрөг /ЕБС-2,709,345.0 СӨБ-1,574,347.4 мянган төгрөг/ -өөр нэмэгдүүлж нийт 4,853,047.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 79,299.5 мянган төгрөгөөр бууруулан төсвийн тодотгол, зохицуулалт хийж /Тус газрын цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 99,748.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 11,295.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,129.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3,619.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 21,200.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 2,000.0 мянган төгрөг зэрэг нийт 150,992.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 273.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 146.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 68,000.0 мянган төгрөг зэрэг нийт 68,419.7 мянган төгрөгөөр бууруулж нийт 651,927.8 мянган төгрөгөөр баталсан. Харин салбарын урсгал шилжүүлгийн зардлыг нийт 127,871.9 мянган төгрөгөөр бууруулсан байна./ 4,773,748.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 4,773,748.1 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,638,763.6 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 5,602.3 мянган төгрөг /Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 5,241.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн

зардлаас 36.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 139.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 1.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 15.5 мянган төгрөг, томилолтын зардлаас 0.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 79.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 87.4 мянган төгрөг/ , тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 103,527.7 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох дэмжлэгийн зардлаас 25,854.5 мянган төгрөг зэрэг нийт 134,984.5 мянган төгрөгийг хэмнэж, жилийн эцэст татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	599,463.1	593,860.8	(5,602.3)	99.0
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	52,464.5	51,163.9	(1,300.6)	97.5
3	Сургуулийн өмнөх боловсрол-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,488,141.2	1,420,082.5	(68,058.7)	95.4
4	Ерөнхий боловсрол-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,633,679.3	2,573,656.4	(60,022.9)	97.7
	<b>Нийт</b>	<b>4,773,748.1</b>	<b>4,638,763.6</b>	<b>(134,984.5)</b>	<b>97.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 115,898.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 109,981.2 мянган төгрөгийг зарцуулан, жилийн эцэст 5,917.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/548 дугаар тушаалаар “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл”-ийн хүрээнд ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин нөхцөлд үнэлгээ хийх ажлын зардал 1,350.0 мянган төгрөг, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийхэд оролцох чиглэлээр эцэг, эхчүүдийн чадавхыг бэхжүүлэх нь” нөлөөллийн үйл ажиллагааны зардалд 1,687.2 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/50 дугаар тушаалаар багш, ажилтан /Боловсролын байгууллагад 1, 5, 10 жил ажиллаж байгаа багш, албан хаагч нарын мэргэжил дээшлүүлэх/-ын үндсэн сургалтад оролцогчдын зардалд 8,610.0 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд СТЕМ боловсролын “Бүтээлч багачууд, шилдэг арга зүй-2023” уралдааны 2 дугаар шатанд оролцогчдын зардалд 4,820.7 мянган төгрөг,

- БЕГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/100 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд “Унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлсэн сайн туршлагыг түгээх” аймгийн зөвлөгөөний зардалд 8,613.0 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/173 дугаар тушаалаар “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Тэгш хамруулан сургах онол арга зүйн сургалт”-ын зардалд 71,798.8 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/256 дугаар тушаалаар “Дотуур байрны хүүхдийн аюулгүй байдал, хөгжил, хамгаалал” сургалтын зардалд 2,882.0 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/265 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүй” сургалтад оролцогчдын томилолтын болон унааны зардалд 5,683.2 мянган төгрөг,
- БЕГ-ын даргын А/407 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулагдах төрөлжсөн олимпиад зохион байгуулах зардалд 4,500.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/106 дугаар захирамжийн дагуу ЗДНХ-өөс 2022-2023 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиадын хоёрын давааны шагнал /Багшийн батламж 48, сурагчийн батламж 111, медаль 159 ширхэг/ -ын зардалд 3,975.0 мянган төгрөг,
- Боловсролын үнэлгээний төвийн даргын А/51 дүгээр тушаалаар сургалтын цайны зардалд 500.0 мянган төгрөг,
- Технологи, дүрслэх урлагийн боловсролын академиас улсын технологийн олимпиадын 3-ын даваанд оролцогчдын унааны зардалд 428.4 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн БШУГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн БШУГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,571,983.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 45,719.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тус газар нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 5,241.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 36.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 139.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 15.5 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 0.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 79.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 87.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 129,382.2 мянган төгрөг зэрэг нийт 134,984.5 мянган төгрөгөөр хэмнэж, төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн БШУГ нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 28 төрлийн 154 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай */бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/* нийцсэн гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1,350.0 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 16,339.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгснийг нотлох баримттай тулган шалгахад бүрэн биелсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,350.0	1	1,350.0	100.0
Албан шаардлага	1	16,339.8	1	16,339.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>17,689.8</b>	<b>2</b>	<b>17,689.8</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,439.0 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс 2,815.2 мянган төгрөгийн 2 зөрчилд нөхөн төлбөрийн акт тогтоож, 1,623.8 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 40.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **2,630.1** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.Үүнд:

- Төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн П.Золжаргалд 1,051.4 мянган төгрөг,
- Нягтлан бодогч Ц.Цэцэгмаад 887.3 мянган төгрөг,
- Нярав Б.Нямгэрэлд 691.4 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Тус газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяад 1, 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 7 дугаар сарын нэмэгдсэн цалингаас тооцож 185.1 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Албан шаардлага

1. Тайлант оны 07 дугаар сард ТАЦНС-д хүний нөөцийн мэдээлэл өөрчлөгдсөнөөс үүссэн тооцооллыг урьдчилан хянаагүйн улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 123.8 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийлгэж байх албан шаардлага хүргүүлэх.

2. “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн санхүүжилтээр “Монгол хэлний хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах дасгал, даалгавар III анги” гарын авлага хийлгэхээр нэмэлт санхүүжилтийн данснаас Мөнхийн үсэг ХХК-д 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлж, гарын авлагыг хүлээн аваагүй атал урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.2 дахь “... **авлага**”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.28 дахь “Бэлтгэн нийлүүлэгч болон хувь хүмүүст төлсөн урьдчилгаа, ба урьдчилан гарсан зардлыг: Дт.Урьдчилж төлсөн төлбөрүүд, Кт.Мөнгөн хөрөнгө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, үүссэн авлагыг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал давхардуулан олгосон.	1	2,630.1	1	2,630.1								
Урамшууллыг илүү тооцож олгосон.	1	185.1	1	185.1								
Төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.	1	123.8			1	123.8						
Урьдчилж гарсан зардлыг бүртгэж, тайлагнаагүй.	1	1,500.0			1	1,500.0						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>4,439.0</b>	<b>2</b>	<b>2,815.2</b>	<b>2</b>	<b>1,623.8</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	-	-	-	-	-	-	-	-